

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2022 оны 06 дугаар сарын 02

1. Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь “Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдүүдийг дэлгэрэнгүй жагсаалтад орон мэдүүлгээ дор дурдсан шаардлагатай мэдээллийн хамт ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь улс, аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан газар, байгалийн нөхцөл, нөөц, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, орон нутгийн уламжлалт онцлогт нийцүүлэн олон төрөлт газрын ашиглалтыг хөгжүүлэх, газрын нөөцийн үр өгөөж, бүтээмжийг дээшлүүлж, урт хугацаанд тогтвортой ашиглахын зэрэгцээ экологийн тэнцвэрт байдлыг хангах замаар нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг дэмжсэн дунд хугацаанд хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад оршино. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг 2022 оны 06 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд хийж гүйцэтгэнэ.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараахь баримт бичгийг баталгаажуулан хавсран ирүүлнэ. Үүнд:
  - Байгууллагын ерөнхий танилцуулга
  - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар **/газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байна/**
  - Сүүлийн 3 жил буюу 2019,2020,2021 онуудад гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл **/ижил төстэй ажил хийсэн жагсаалт, гэрээг ирүүлнэ/**
  - Зөвлөх хуулийн этгээдийн ажиллах боловсон хүчний талаарх мэдээлэл **/ажилчдын мэргэжлийн дипломын хуулбар, ур чадвар, туршлагыг нотлох мэргэшлийн үнэмлэх, бусад нотлох баримтууд/**
4. Сонирхсон хуулийн этгээд нэмэлт мэдээллийг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл ажлын цагаар авч болох бөгөөд мэдүүлгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ хаягаар 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 15 цаг 00 минутаас өмнө ирүүлнэ үү.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Баянбулаг баг.

Засаг даргын Тамгын газар

Холбогдох утас: Засаг дарга Н.Гансүх **99209086**

Газрын даамал Л.Цэндсүрэн **89539633**

Санхүүгийн албаны дарга Д.Аюуш **99940570**